

## АРИЛЖААНЫ ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэ журам нь Биржийн арилжааг холбогдох хууль, журам Биржийн стандарт гэрээний хүрээнд зах зээлд оролцогчдын Хөдөө аж ахуйн бирж /цаашид “Бирж” гэх/-ийн арилжаанд оролцохтой холбоотой нарийвчилсан харилцааг зохицуулна.
- 1.2. “Биржийн үйл ажиллагааны ерөнхий журам”/цаашид Ерөнхий журам гэх/-д заасны дагуу энэ журам, түүнд оруулах нэмэлт өөрчлөлтийг Биржийн Гүйцэтгэх удирдлага батална.
- 1.3. Гүйцэтгэх удирдлага өөрөөр шийдвэрлээгүй бол энэ журам, түүнд оруулах нэмэлт өөрчлөлтийг хүчин төгөлдөр мөрдөж эхлэх өдрөөс хуанлийн 7 хоногийн өмнө нийтэд мэдэгдэнэ.

### ХОЁР. БИРЖИЙН ГЭРЭЭ

- 2.1. “Биржийн гэрээ” гэдэг нь Биржээр арилжаалах жагсаалтад орсон бараа, түүхий эдэд суурилсан гэрээг хэлнэ.
- 2.2. “Стандарт гэрээ” гэдэг нь энэхүү журмын 2.1-т заасан Биржийн гэрээг арилжаалах нөхцөл, арга хэлбэрийг тодорхойлсон баримт бичиг байна.
- 2.3. Энэхүү журмын 2.1, 2.2-т заасан баримт бичгийг Гүйцэтгэх удирдлага батална.

### ГУРАВ. АРИЛЖААНД ОРОЛЦОГЧ

- 3.1. Дараах этгээд Биржийн арилжаанд оролцоно. Үүнд:
  - 3.1.1. **Байнгын гишүүн** өөрийн болон харилцагчийн нэрийн өмнөөс захиалга оруулна. Байнгын гишүүн нь арилжааны цорын ганц зуучлагч байна.
  - 3.1.2. **Байнгын гишүүний харилцагч** байнгын гишүүнтэй зуучлалын гэрээ байгуулж, данс, арилжааны данс нээлгэсний үндсэн дээр арилжаанд оролцоно.
  - 3.1.3. **Байнгын бус гишүүн** байнгын гишүүнтэй зуучлалын гэрээ байгуулж, данс арилжааны данс нээлгэсний үндсэн дээр арилжаанд бие даан оролцох эрх үүснэ.
- 3.2. Арилжаанд оролцогч нь Биржийн холбогдох журмаас гадна “Арилжаа хөтлөгч”-ийн зааварчилгаа, шаардлагыг дагаж мөрдөнө.
- 3.3. Арилжаанд оролцогч нь арилжааны нийт үед Биржийн арилжааны системд зөвшөөрөгдсөн үйлдлийг хийх эрхтэй бөгөөд бусад оролцогчдод саад болох аливаа үйлдэл гаргахгүй байх үүрэгтэй.

### ДӨРӨВ. ЗАХИАЛГЫН БҮРТГЭЛ

#### Захиалгын төрөл

- 4.1. Арилжаанд оролцогч Ерөнхий журмын 5.5-д заасан дараах захиалгуудыг оруулна. Үүнд:
  - 4.1.1. **Зах зээлийн захиалга:** тухайн үеийн зах зээлийн хамгийн сайн үнээр шууд биелэх ба захиалгыг биелүүлэхдээ захиалга оруулсан хугацааны эрэмбийг мөрдөнө.

- 4.1.2. **Нөхцөлт захиалга:** захиалгыг оруулсан үнээс сайн үнээр биелэх ба үнэ хугацаа гэсэн эрэмбийг мөрдөнө.
- 4.1.3. **Кросс захиалга:** талууд урьдаас хэлэлцэн тохиролцсон арилжааны захиалга.
- 4.1.4. **Зах зээл үүсгэгчийн захиалга:** Биржээс тогтоосон хэмжээнээс хэтрэхгүй зөрүүтэй үнээр авах, зарах захиалга ба зах зээл үүсгэгч нь арилжааны үед тасралтгүйгээрзах зээл үүсгэгчийн захиалгаар арилжааг хангах үүрэгтэй.
- 4.2. Арилжаанд оролцогч кросс захиалгаар өдөрт нэг удаа хэлцэл гүйцэтгэх боломжтой бөгөөд биелэх хэлцлийн хэмжээ 1000 (нэг мянга) гэрээнээс хэтрэхгүй байна.
- 4.3. Кросс захиалгын үнийг хаалтын үед тухайн Биржийн гэрээний дараах гурван үнийн аль өндөр үнээр биелүүлнэ. Үүнд:
  - 4.3.1. Тухайн өдрийн зах зээлийн болон нөхцөлт захиалгуудаас тогтсон үнэ;
  - 4.3.2. Тухайн өдрийн Биржийн дундаж үнэ;
  - 4.3.3. Тухайн захиалгын үнэ.
- 4.4. Кросс захиалгаар хийгдэх хэлцлийн үнийг арилжааны системийн захиалгын бүртгэлээр оруулах боловч үнэ тогтооход оруулахгүй, зөвхөн арилжааны мэдээнд оруулна.

### **Захиалгын бүртгэл**

- 4.5. Арилжаанд оролцогчийн оруулсан захиалгыг арилжааны програмд бүртгэгдсэн хугацааны эрэмбээр дугаарлаж, захиалгын бүртгэлийн санд хадгална.
- 4.6. Ерөнхий журмын 5.13.1-т заасан аргачлалаар үнэ тогтох үед захиалга биелэх дараалал дараах эрэмбээр явагдана.
  - 4.6.1. Үнийн эрэмбэ: өндөр үнээр худалдан авах, бага үнээр зарах захиалга нь бусад захиалгаас өмнө биелэгдэх давуу эрэмбэтэй байна.
  - 4.6.2. Цаг хугацааны эрэмбэ: захиалгын үнийн ижил төвшинд захиалга биелэгдэх нөхцөл бүрдсэн бол цаг хугацааны хувьд эхэнд оруулсан захиалга нь бусад захиалгаас өмнө биелэгдэх давуу эрэмбэтэй байна.
- 4.7. Ерөнхий журмын 5.13.2-т заасан аргачлалаар үнэ тогтох үед захиалга биелэх дараалал дараах эрэмбээр явагдана. Үүнд:
  - 4.7.1. Үнийн эрэмбэ: өндөр үнээр худалдан авах, бага үнээр зарах захиалга нь бусад захиалгаас өмнө биелэгдэх давуу эрэмбэтэй байна.
  - 4.7.2. Цаг хугацааны эрэмбэ: захиалгын үнийн ижил төвшинд захиалга биелэгдэх нөхцөл бүрдсэн бол захиалгууд дараах эрэмбээр биелнэ. Үүнд:
    - 4.7.2.1. Тухайн гэрээний арилжаанд зах зээл үүсгэгчийн захиалгууд бусад оролцогчдын захиалгаас давуу эрэмбэтэй байна. Хэрэв ижил үнийн төвшинд олон зах зээл үүсгэгчдийн захиалга хийгдсэн бол цаг хугацааны хувьд эхэнд оруулсан захиалга нь бусад захиалгаас өмнө биелэгдэх давуу эрэмбэтэй байна;
    - 4.7.2.2. Зах зээл үүсгэгчдээс бусад оролцогчдын захиалгын үнийн ижил төвшинд захиалга биелэгдэх нөхцөл бүрдсэн бол цаг хугацааны хувьд эхэнд оруулсан захиалга нь бусад захиалгаас өмнө биелэгдэх давуу эрэмбэтэй байна.

### **Нэмэлт нөхцөл**

- 4.8. Арилжаанд оролцогч нь Ерөнхий журмын 5.5-д заасан захиалгууд дээр дараах нэмэлт нөхцөлүүдийг оруулж болно. Үүнд:
  - 4.8.1. Оролцогч биелэх хэмжээтэй холбоотой дараах нөхцөлүүдийг оруулж болно
    - 4.8.1.1. Хэсэгчлэн биелэх захиалгын доод хэмжээг заах;
    - 4.8.1.2. Хэсэгчлэн биелсэн захиалгын биелээгүй үлдсэн захиалгыг цуцлах.
  - 4.8.2. Оролцогч арилжаанд захиалгын хүчинтэй байх хугацааг заасан дараах нөхцөлүүдийг оруулж болно. Үүнд:

- 4.8.2.1. *Тухайн агшинд хүчинтэй*: тухайн агшинд үнэ бодогдоход биелээгүй бол цуцлагдана;
  - 4.8.2.2. *Арилжааны нэг үед хүчинтэй*: тухайн арилжааны үеийн эцэст цуцлагдана;
  - 4.8.2.3. *Өдрийн турш хүчинтэй*: тухайн өдрийн арилжааны эцэст цуцлагдана;
  - 4.8.2.4. *Заасан хугацаанд хүчинтэй*: тухайн заасан хугацааны эцэст цуцлагдана;
  - 4.8.2.5. *Цуцлах хүртэл хүчинтэй*: тухайн захиалга цуцлагдах хүртэл эсвэл хуанлийн 90 хоногт цуцлагдана.
- 4.8.3. Оролцогч арилжаанд захиалгын нийт хэмжээг хэсэгчлэн хувааж, захиалга бүрийн зарим хэсгийг бусдад харагдахаар оруулж болно. Харагдахаар хийгдсэн захиалга биелэхэд дараагийн үлдсэн далд хэсгийн захиалга ил гарах ба тухайн захиалгын эрэмбэ захиалга ил гарах үеийн хугацаагаар эрэмбэлэгдэнэ.
- 4.9. Захиалгын нөхцөлийг сонгоогүй тохиолдолд арилжааны системд тохируулсан нөхцөлөөр бүртгэгдэнэ.
- 4.10. Тодорхой нэг гэрээний арилжааг энэ журмын 5.5.3-т заасан арилжааны үед энэ журмын 5.12, 5.13-т заасан үндэслэлээр арилжааг түр зогсоосон үед оролцогчид биелээгүй үлдсэн захиалгыг цуцалж болох ба зах зээл үүсгэгчээс бусад оролцогч нэмж захиалга оруулах, захиалгад өөрчлөлт оруулахыг хориглоно.
- 4.11. Арилжааны үед оролцогч захиалгыг оруулсны дараа захиалга биелээгүй эсвэл хэсэгчлэн биелж, биелээгүй үлдсэн захиалга байвал оролцогч захиалгыг өөрчлөх эсвэл цуцалж болно. Арилжаанд оролцогч захиалгад энэ журмын 4.8.1, 4.8.2-т заасан нэмэлт нөхцөлд өөрчлөлт оруулсан тохиолдолд захиалгын эрэмбэ өөрчлөгдөхгүй бөгөөд бусад бүх өөрчлөлтөд захиалгыг өөрчлөлт хийсэн үеийн хугацаагаар эрэмбэлэнэ.

## **ТАВ. АРИЛЖАА ЗОХИОН БАЙГУУЛАХ**

- 5.1. Арилжааг Ерөнхий журмын 5.3-т заасан хэлбэрээр зохион байгуулах ба арилжааг дугаарлана.

### **Арилжаа зохион байгуулах этгээд**

- 5.2. Арилжааны үеүдэд арилжаа зохион байгуулахаар дараах этгээдүүд арилжааны системд холбогдоно. Үүнд:
- 5.2.1. Арилжаа хөтлөх үүрэг бүхий “Арилжааны албаны мэргэжилтэн” (цаашид “арилжаа хөтлөгч” гэх).
  - 5.2.2. Арилжааг холбогдох журмын дагуу зохион байгуулагдаж буйг хянах үүрэг бүхий “Хяналт, мониторингийн албаны мэргэжилтэн”.
  - 5.2.3. Арилжаанд оролцогчийг бүртгэх, танхимын арилжаанд туслах үүрэг бүхий “Арилжааны албаны мэргэжилтэн”.
  - 5.2.4. Арилжаанд оролцогчийн техник, хэрэгсэл, програм хангамжийн найдвартай ажиллагааг хангах, засвар үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий “Мэдээллийн технологийн албаны мэргэжилтэн”.
- 5.3. Энэ журмын 5.2-т заасан этгээд арилжааны бэлтгэл ажлыг хангах ба арилжаа эхлүүлэх шийдвэрийг арилжаа хөтлөгч гаргана.
- 5.4. Онлайн арилжааны хувьд арилжаа хөтлөгч “Биржийн стандарт гэрээ”-д заасан цагийн хуваарийн дагуу энэ журмын 5.5-д заасан үе бүрийн эхлэх, дуусах мөчийг оролцогчид цахим хэлбэрээр, танхимын арилжааны хувьд арилжаа нээх, хаахад цанг тус бүр нэг удаа цохиж мэдэгдэнэ.

## Арилжааны үе, хуваарь

- 5.5. Арилжаа нь арилжааны бэлтгэл үе, нээлтийн үе, үндсэн үе, хаалтын үе гэсэн 4 үетэй ба эдгээрийн үе бүрд тогтсон үнээр боломжит захиалга биелэх ба цагийн хуваарийг “Биржийн стандарт гэрээ”-д заана.
  - 5.5.1. Бэлтгэл үед Бирж болон арилжаанд оролцогчид Биржийн арилжааны системийн бэлэн байдлыг шалгаж, захиалгыг бүртгэж эхэлнэ.
  - 5.5.2. Нээлтийн үед Ерөнхий журмын 5.13.1-т заасан аргачлалаар зөвхөн нэг үнэ тогтох бөгөөд Ерөнхий журмын 5.5.1, 5.5.2-т заасан захиалгуудыг зөвшөөрнө.
  - 5.5.3. Үндсэн үед “Биржийн стандарт гэрээ”-д заасан аргачлалаар үнэ тогтох бөгөөд Ерөнхий журмын 5.5-д заасан захиалгуудыг зөвшөөрнө.
  - 5.5.4. Хаалтын үед Ерөнхий журмын 5.13.1-т заасан аргачлалаар зөвхөн нэг үнэ тогтох бөгөөд Ерөнхий журмын 5.5.1, 5.5.2-т заасан захиалгуудыг зөвшөөрнө.
- 5.6. Арилжаанд оролцогч арилжааны үед шаардлагатай тодруулга авах бол арилжааны програм ашиглан “Арилжаа хөтлөгч”-д хандаж болно.
- 5.7. Арилжаанд оролцогчийн биелсэн захиалгын жагсаалтыг арилжааны програмаар дамжуулан авч болох бөгөөд шаардлагатай тохиолдолд “Арилжаа хөтлөгч”-өөс хэвлэмэл хэлбэрээр авч болно.
- 5.8. Биржийн гүйцэтгэх удирдлагын шийдвэрээр Биржийн арилжааны цагийн хуваарийг тодорхой шалтгааны улмаас өөрчилж болно. Энэ тухай мэдээллийг ажлын 1 өдрийн өмнө арилжаанд оролцогчдоод мэдэгдэнэ.
- 5.9. Тодорхой нэг гэрээний арилжааг үндсэн үед энэ журмын 5.12, 5.13-т заасан үндэслэлээр түр зогсоож, арилжааг үргэлжлүүлэн явуулах бол Ерөнхий журмын 5.13.1-т заасан аргачлал, 5.5.1, 5.5.2-т заасан захиалгуудаар нэг удаа үнэ тогтоож, үндсэн үерүү шилжинэ.

## Хязгаарлалт

- 5.10. Бирж арилжааны үеүдэд тогтох үнийг дор дурдсаны дагуу хязгаарлаж, хяналт хэрэгжүүлнэ.
  - 5.10.1. Бирж дараах жишиг үнэ, баримтлах үнийг тогтоон үнийн хяналтад ашиглана.
    - 5.10.1.1. **Жишиг үнэ:** Фьючерс, форвард, опцион гэрээний жишиг үнэ нь өмнөх өдрийн хаалтын үнэ. Спот гэрээний жишиг үнийг Биржийн үнэ, зэрэгцээ зах зээлийн үнэ, гадаад зах зээлийн үнэ, валютын ханшны өөрчлөлт зэргийг тооцож EWMA аргачлалаар тогтооно.
    - 5.10.1.2. **Баримтлах үнэ:** Хамгийн сүүлд биелсэн хэлцлийн үнэ.
  - 5.10.2. Тухайн гэрээний арилжааны үнэд жишиг үнэ болон баримтлах үнээс дээш доош тодорхой хувиар үнийн хязгаарлалтыг хийх ба хязгаарлалтын хэмжээг “Биржийн стандарт гэрээ”-д заана.
- 5.11. Арилжаанд оролцогчийн эрхийн хэмжээнээс шалтгаалан тухайн оролцогчийн болон түүний харилцагчдын нийт позицын хэмжээг хязгаарлаж болох ба хязгаарлалтын хэмжээг “Биржийн стандарт гэрээ”-д заана.

## Арилжааг түр зогсоох

- 5.12. Бирж арилжааны үед үнийн өөрчлөлт “Биржийн стандарт гэрээ”-д заасан тодорхой хязгаарлалтаас хэтэрсэн, техникийн саатал болон давагдашгүй хүчин зүйл тохиолдсон бол арилжааг хэсэгчлэн болон нийтэд нь түр зогсоож, эсвэл хугацаанаас нь өмнө хааж болно.
- 5.13. Биржийн гэрээний үнэд санаатайгаар дангаар болон бусадтай үгсэн хуйвалдаж нөлөөлөх сэжиг бүхий захиалга, хэлцлүүд хийгдсэн тохиолдолд тухайн захиалгуудыг

царцаах, арилжааг хэсэгчлэн болон нийтэд нь түр зогсоож, эсвэл хугацаанаас нь өмнө хааж болно.

- 5.14. Бирж энэ журмын 5.12, 5.13-т заасан үндэслэлээр арилжааг түр зогсоож, эсвэл хугацаанаас нь өмнө хаасны дараа өмнө нь хийгдсэн захиалга болон хэлцлүүдийг хэсэгчлэн болон нийтэд нь хүчингүй болгож болно.

## **ЗУРГАА. АРИЛЖААНЫ МЭДЭЭ**

- 6.1. Биржийн арилжааны мэдээг өдөр, долоо хоног, сар, улирал жилээр, Биржийн үнийн индексийг арилжааны өдөр бүр бодож энэ журмын 6.4-т заасан сувгаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ. Биржийн мэдээнд гэрээний нэр, үнэ, хэмжээ, хугацааг тусгасан байна.
- 6.2. Биржийн арилжааны үнийн индексийг холбогдох журам, тушаалын дагуу тогтоосон аргачлалаар тооцно.
- 6.3. Төрийн байгууллага болон Биржийн гишүүн байгууллагуудад шаардлагатай мэдээг агуулга, хүргэх хэлбэр, давтамжийг харилцан тохиролцсоны үндсэн дээр хүргүүлнэ. Биржийн гүйцэтгэх удирдлагын зөвшөөрлөөр эрх бүхий байгууллагаас шаардсан мэдээг гаргаж өгч болно.
- 6.4. Арилжааны мэдээг, түүний төрлөөс хамааруулан дараах хэлбэрээс аль тохирох хэлбэрээр мэдээлнэ. Үүнд:
- 6.4.1. Биржийн албан ёсны цахим хуудас;
  - 6.4.2. Танхимын дэлгэц;
  - 6.4.3. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл;
  - 6.4.4. Цахим шуудан;
  - 6.4.5. Хэвлэмэл хэлбэрээр.
- 6.5. Биржийн мэдээллийг хуулийн этгээд албан хэрэгцээндээ тогтмол хэрэглэх хүсэлт тавьсан тохиолдолд энэ харилцааг 2 талын харилцан байгуулсан гэрээгээр зохицуулна.
- 6.6. Биржийн арилжааны мэдээ, тайлан болон статистик тоо, баримт нь Биржийн өмчид хамаарна.

## **ДОЛОО. ХАРИУЦЛАГА**

- 7.1. Арилжаанд оролцогч энэ журмыг зөрчсөн, эсвэл дараах хориглосон заалтыг зөрчсөн тохиолдолд “Хяналтын журам” болон бусад хууль, эрх зүйн баримт бичгийн хүрээнд хариуцлага хүлээнэ. Үүнд:
- 7.1.1. Харилцагчийн захиалгын цаг хугацааны дараалалд өөрчлөлт оруулсан, захиалгын маягтын дагуу зөв бүртгүүлээгүй;
  - 7.1.2. Биржийн гэрээний үнэд санаатайгаар дангаар болон бусадтай үгсэн хуйвалдах замаар нөлөөлөхийг оролдох (манипуляци);
  - 7.1.3. Бусад оролцогчийг төөрөлдүүлэх, худал мэдээлэл тараах;
  - 7.1.4. Арилжааны хэвийн үйл ажиллагаанд саад учруулах.
- 7.2. Арилжаанд оролцогч энэ журам болон арилжаатай холбоотой аливаа эрх зүйн баримт бичгийг мэдээгүй, эсвэл ойлгоогүй нь хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.